

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-ийн “....цэвэр ус дамжуулах, түгээх гэсний дараа цэвэр усны гаргалгааны” гэж нэмэх

2 дугаар зүйл. Энэ хуулийг Орон сууцны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 146 дугаар зүйлийн 146.1, 147 дугаар зүйлийн 147.1-ийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ “146.1.Дангаар өмчлөх өмчлөлийн зүйлд энэ хуулийн 142 дугаар зүйлд заасан талбай, хуулиар зөвшөөрсөн, түүнчлэн дундаа буюу дангаар өмчлөгч өөр этгээдийн эрхийг зөрчихөөргүй, эсхүл барилгын гадаад төрх байдлыг алдуулахгүйгээр өөрчилж, тусгаарлаж, нэмж сайжруулж болох түүний бүрдэл хэсэг хамаарна.”

2/ “147.1.Сууц өмчлөгч нь өөрийн өмчлөлд байгаа сууц болон сууцны бус зориулалттай хэсгийн халаалт, халуун, цэвэр, бохир ус, ариутгал, хог, цахилгаан, холбоо зэрэг ашиглалтын төлбөр, дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардлыг эрх бүхий байгууллагад төлнө.”

2 дугаар зүйл.Иргэний хуулийн 143, 144, 149 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.6 дах хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Орон сууцны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орон сууц хувьчлах тухай хуулийн 2 дугаар зүйлийн “Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай гэснийг Орон сууцны тухай” гэж өөрчлөх.

2 дугаар зүйл. 11 дүгээр зүйлийн “9/орон сууц өмчлөгчдийн холбоо байгуулахад арга зүйн туслалцаа үзүүлэх;” гэснийг хүчингүй болгосугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Орон сууцны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.5 дах хэсгээс “сууц өмчлөгчдийн холбооны төлөөлөл,” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Орон сууцны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Орон сууцны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ